

НОМ ӨГҮҮЛЛИЙН ШҮҮМЖ

ТӨВДИЙН ТҮҮХЭНД ӨНГӨЦХӨН ХАНДАЖ БАЙГАА НЬ
(Шүүмж)

Бүгд Найрамдах Хятад Ард Улс сүүлийн жилүүдэд үндэсний цөөнхийн талаар нэлээд анхаарал тавьж, тэдний түүх, нийгэм-улс төр, эдийн засаг, соёл, угсаа гаралын асуудлыг сөхөн тавих нэрээр сурталчилан судлах ажил явуулж, хэвлэл мэдээллээр дамжуулан ном, өгүүлэл, цуврал зэргийг хэвлэн нийтлэх болов. Түүний дотроос төвд үндэстний түүх, нийгэм-улс төрийн байгууламж, эдийн засаг, соёлын талаар баримталж ирсэн байр суурь, уг угсаатны үндэстний гаралын асуудлаар өнгөрсөн онуудад тухайлан 1983, 1984 онд хэд хэдэн өгүүлэл цуврал гарав. Үүнд: Лувсан, Жин Юн нарын хамтран бичсэн “Төвдийн шог түүх”¹, Хятадын үндэстнүүдийн институтийн захирал Я.Ханзаны бичсэн “Далай ламын өгүүллэг” номын тухай Жоу Шу-гийн бичсэн “Төвдийн түүхийн үнэн байдлыг сөхөн тавихад”², Ван Дуньюйгийн бичсэн “Ламын шашин ба төвдийн хүн ам”³ гэх мэт хэд хэдэн өгүүлэл нийтлэгдэв.

Одоо бидний өгүүлэн буй өгүүллийг бичсэн Лувсан (төвд үндэстэн), Жин Юн (хан үндэстэн) нар нь Хятадын үндэстнүүдийн түүх судлаачид бөгөөд тэдний бичсэн энэхүү “Төвдийн шог түүх” хэмээх өгүүлэл “Бээжин ревью” сэтгүүлийн 1983 оны № 24, 26-д гарсан юм. Уг өгүүллийн 2 хэсэг нь ерөнхий гарчигтай, ерөнхий гарчиг нь дотроо хэд хэдэн жижиг гарчигтай. Үүнд:

1-р хэсгийн ерөнхий гарчигт

- 1.Эрт цагийн сайн хөршийн дотно харилцаа
- 2.Соронзонгомбо ба Вэнчин гүнж
- 3.Жинчин гүнж ба Чидэ зүгзайн
- 4.Тан ба Төвдийн холбоо
- 5.Цай, агт морины арилжаа

2-р хэсгийн ерөнхий гарчигт

- 6.Хятадын салшгүй бүрэлдэхүүн хэсэг
- 7.Төр, шашныг нэгтгэн барихуй нь
- 8.Мин-Төвдийн харилцаа
- 9.Далай лам, Ванчин Эрдэнэ
- 10.Дээд эрхт засгийн газар (Гаша) гэсэн олон жижиг гарчигт хуваажээ. Энэ 1-р хэсгийн гол агуулга нь Төвд үндэстний түүх, нийгэм, улс төрийн байгууламжийн асуудлаар VI зууны шувтаргаас XVIII зуун хүртэлх үеийг товч хураангуйлан багтаасан байна. Уг

¹ “Бээжин ревью” 1983, VI, 13, № 24, 19-24-р тал, мөн сэтгүүл 1983 VII, 13, № 26, 25-29-р тал

² “Бээжин ревью” 1984, IX, 17, № 38, 32-34-р тал

³ “Үндэсний асуудал” 1984, № 2, 44-55-р тал

өгүүлэлд “Соронзонгомбо ба Вэнчин гүнжийн тухай бичихдээ: “Төвдийн уулархаг орон, Ярлун аймгийн удирдагч байсан Нанрилойнзайнгийн хүү Соронзонгомбо VII зууны шувтаргаар газар нутгийг нэгтгэн, боолын байгуулалт Төвдийн вант улсыг байгуулав”⁴ гэжээ. Соронзонгомбо хаан (605-649) Тан улсад элч илгээж хааны гүнжийг авч Тан улсын хаантай ураг төрлийн холбоо тогтоох хүслээ илэрхийлсэн боловч эзэн хаан татгалзсаны хариуд Төвдийн хаан Соронзонгомбо “Тан улсын баруун хойд хилээр довтолсноор Тан улсын эзэн хаан Тайзунтай хэлэлцээ хийхээр ирсэнд талархан Вэнчин гүнжийг Соронзонгомбод эхнэр болгон 641 онд явуулжээ.”⁵ Тан улсын Тайзун хааны гүнж Соронзонгомбо хаанд хатан болсон түүхэн үйл явдал нь Төвд, Тан хоёрын хооронд дайн хийх шалтгааныг арилгасан, нөгөө талаар Төвдийн хилийн довтолгооныг Тан улс зогсоон түвшитгэх зорилгоор Вэнчин гүнжийг Төвдийн хаанд гэргий болгон өгсөн ажээ. Үүнээс үзэхэд эрт дээр үеэс төвд үндэстэн Хятадын түшмэг улс биш, биеэ даасан төртэй эзэнт улс байсан нь тодорхой байна.

Хятадын үндэстний цөөнхийн түүхийг судлагч Лувсан, Жин Юн нарын бичсэн өгүүлсэн өгүүлэлд Соронзонгомбод Вэнчин гүнийг эхнэр болгосон явдлыг бодит байдлаас гажуудуулан түүхийг үздэг Хятадын уламжлалт үзлийг баримталж, хүн төрөлхтний хувь заяанд аль нэгэн ард түмэн онцгой чухал үүрэгтэй гэсэн үндэстний дээрэнгүй үзлийг түүх бичлэгийн арга барилдаа овжин ашиглах оролдлого хийсэн нь дээрхээс тодорхой байна. Нөгөөтэйгүүр төвдийн ард түмний бүтээсэн нийгэм, соёлын түүхийг үгүйсгэж, түүхийг ганц нэгэн гарамгай хүн бүтээдэг мэтээр үзэж, Вэнчин гүнжийг Төвдийн нийгэм, соёлын хөгжлийг урагш давшуулсан байдлаар бичсэн нь марксист-ленинист биш хандлага билээ. Тухайлбал, Төвд, Тан улсын хооронд гадаад харилцаа тогтон хөгжиж байсан нь тус хоёр орон адилхан биеэ даасан, тэгш эрхтэй, тусгаар тогтносон улс байжээ. Ертөнцийг ноёлох хятад үзлийн талаар Джавахарлал Неру бичихдээ, “Хятадын эзэн хааныг тэнгэрийн хүү” гэж хятад нэрлээд ертөнцийг захирагч мэт үздэг юм”⁶ гэжээ. Тэд өөрсдийгөө тэнгэрийн зарлигтай мэт үзэж, улмаар Хятад орноор барахгүй, зэргэлдээх хятад бус ард түмнийг захирах ёстой мэт болсноор хятад төвийн үзэл бүрэлдэн тогтсон ажээ. Уг өгүүлэлд бодит байдлыг тийнхүү мушгин дүрсэлсний уршгаар ард түмний жинхэнэ түүх, хятад ба хятад бус ард түмнүүдийн хоорондын бодит харилцааг гуйвуулан бичих явдал харагдаж байна. Түүгээр ч үл барам биеэ даасан тусгаар улс элчээ Хятадын эзэн хаанд явуулсан болон гадаад харилцааны ерийн заншлаар харилцан бэлэг барихыг түшмэг хараат орон үүргээ биелүүлэн, алба барьж байсан мэтээр бичиж байна. Төвдийн Соронзонгомбо хаан төвдийн эзэнт төр улсыг байгуулж “69 жил хаант төрийг барьж 82 настайдаа нас барсан” мэдээ буй.⁷ Соронзонгомбо хааны талаар зарим зөрүүтэй мэдээ байгаа бөгөөд тухайлан түүний төрсөн он хэд хэдэн сурвалж материалд янз бүрээр бичигдсэн байдаг юм. Харин Шоннубалын (1392-1481) “Хөх дэвтэр”-т бичихдээ, “Соронзонгомбо 569 онд төрсөн нь маргаангүй”⁸ гэжээ. Мөн цахар гэвш Лувсанчүлтэмийн (1740-

⁴ “Бээжин ревью” 1983, VI, 13, № 24, 19-р тал

⁵ The Buddhism of Tibet or Lamaism. 20 tal, Cambreidge 1967, reprinted

⁶ “Взгляды на всемирную историю” 1 том, М, 1981, 150-р тал

⁷ Histori Buddhism (Choin gung) by Bu-ston in part translated from Tibetan by Dr.E.Obermiller Heideiberge 1932, 185 tal

⁸ Ю.Н.Перрах Избранные труды” Москва, 1967, 266-р тал

1810) зохиол “Зонховын намтар”-т бичсэнээр “Хожуу Соронзонгомбо 82 сүүдрийн дээр гаслангаас гэтлэхүй ёсыг үзүүлэхийн цагт гүнж сэлтэст 2 зууд тахил агаа ихийг өргөх бөгөөс ерөөл тавив”⁹ гэжээ. Иймд Соронзонгомбо хаан 650 онд нас барсан гэдэг мэдээнээс үзвэл, 82 настай таалал төгсчээ.

Одоо Соронзонгомбо хааны хоёр хатны барьсан их, бага 2 зургийн сүмийн хаалганы өмнө буй Тан, Төвдийн холбооны хөшөөний тухайд цухас дурдъя. Энд Тан, Төвдийн хооронд урагийн холбоо бий болсноор 821 онд хятад, төвд хэлээр Лхасын Их зуугийн хаалганы өмнө бичээстэй “Тан, Төвдийн холбооны хөшөө”-ний үг үсгийг гүйцээж сийрүүлэн, утга санааг тайлбарлаж бичжээ.¹⁰ Үүнээс үзэхэд уг хөшөөг Соронзонгомбо хааныг нас барснаас хойш 171 жилийн дараа босгожээ. Энэ хөшөөний үг, үсэг өгүүлбэр тэр бүр харагдахгүйгээр арилсан боловч энд тэндээс зарим нэгэн үг, үсгээс мэдэгдэж байгааг буулгаж тавьснаас үзэхэд “Их Тан ... эзэн хаан (хуанди), Их Төвд ... худ худгүй хоёр биенийг төлөөлөн хэлэлцэж ... эв нэгдэл ... холбооны гэрээ, үүрд хувиршгүй...”¹¹ гэжээ. Харин Лувсан, Жин Юн нарын бичсэн “Төвдийн түүхийн шог” өгүүлэлд уг хөшөөний бичгийг бүрэн гүйцэд байгаа мэтээр тайлбарлан бичжээ. Гэтэл Ван Фүрэн, Сүвэнди¹² нарын зохиосон “Төвд үндэстний товч түүх” (Сычуань, 1980) гэдэг номонд хөшөөний талаар хийсэн тайлбар нь хөшөөний жинхэнэ эхтэй тохирохгүй байгаа ажээ. Юуны өмнө уг хөшөөний үг, үсгийг сийрүүлэхдээ дур зоргоороо засварлаж нөхөн бичсэн ажээ. Үүнд Ван Фүрэн, Сүвэнди нарын бичсэн “Төвд үндэстний товч түүх” гэдэг номонд энэ хөшөөний бүрэн эхийг сийрүүлэн бичсэнээс ажиглахад “их найрамдал”¹³ гэдгийг “эв нэгдэл” гэсэн үгийн араас залгасан байх бөгөөд харин Ван Фүрэн, Сүвэнди нарын бичсэн нь “худ, худгүй” гэдгийг “нэгэн гэр бүл” гэсэн утгаар тайлбарлан бичжээ. Мөн хөшөөнд “тус бүрийн хил хязгаарыг сахин хамгаална. Харилцан үл довтолно”¹⁴ гэжээ. Энэхүү найрамдлын гэрээний хөшөөнд бичсэнээс үзэхэд энэ хоёр улс орон тус бүрдээ хил хязгаартай, тусгаар биеэ даасан эзэнт улс байсан, тэр тусмаа харилцан найрсаг байхаар тогтон хэлэлцэж гэрээ байгуулсан нь тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл уг хөшөөний үг өгүүлбэрийг хятад төвийн үзлийн үүднээс зориуд гуйвуулан засаж байсан нь илт байна. Ингэж Хятадын зарим түүхчид эртний соёлын дурсгалт хөшөө, сурвалж материалыг өөрсдийн дураар гуйвуулж байгаа нь үндэстний цөөнхийн түүх соёлын дурсгалт зүйлийг судлахад хохирол учруулж, Хятадын болон үндэстний цөөнхийн түүхэн ховор сурвалж материалд үнэмших итгэлийг бууруулан, улмаар дэлхий дахины учир холбогдолтой эртний соёлын өвийг судлагч эрдэмтэн мэргэдийг төөрөгдүүлэхэд зориулж байна. Нөгөөтэйгүүр Хятадын түүхчид түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засах нэрээр түүнийг шууд хүчээр засварлах, ховор нандин дурсгалт зүйлийг ул мөргүй болгож байгаа нь түүхийг завхруулан гуйвуулж байгаагийн нотолгоо мөн.

Лхаст байгаа их, бага 2 зуу дуганы хувьд Их зуугийн дуганыг Балбын Амчаварманы охин Жавзун барьсан, Их зуугийн дуганыг

⁹ “Зонховын намтар” 19х100 хүрээ бар, 17-р тал

¹⁰ “Бээжин ревью” 1983, № 24, Ван Фу рэн, Сүвэнди “Төвд үндэстний түүх”, Сычуань, 1980, 244-р тал

¹¹ Sourcebook on Buddhism in mainland China (1949-1967) 1967, Gon-Kong 475 tal

¹² Ван Фүрэн, Сүвэнди “Төвд үндэстний товч түүх” 244-р тал Сычуань, 1980

¹³ Мөн тэнд

¹⁴ Мөн тэнд, 35-р тал

хаалга баруун тийшээ харсан нь Балбын гүнж нутаг юугаан харж буйн шинж, бага зуугийн дуганын хаалга зүүн тийшээ харсан нь Хятадын Вэнчин нүнж нутаг юугаан харж байгаагаар барьсан гэдэг ажээ. Төвдөд энэ хоёр гүнж их, бага 2 (зуу) Шагжаймунын дүрийг залж авчирсан гэдэг ажээ. Харин Хятадын улаан хамгаалагчид Балбын гүнжийн (зуу) Шагжаймунын дүрийг эвдэж сүйтгэсэн бөгөөд түүний толгойн эвдэрхий одоо энэтхэгт Дхармасалагийн гол дуганд байдаг ажээ.

Лхаст буй өөр бас нэг хөшөөний тухай нэгэн мэдээг өгүүлэхэд: “Жинчин гүнжийн хүү Тэсрэнтизэнгийн дурсгалын хөшөө нь урт гонзгой хэлбэртэй хөшөөний үгс нь төвд хэлээр байдаг ажээ. Түүний гол утга санаа нь тэр “Тан улсын вантай дайтсан буюу хавчигдан зугатаж Жиан Жоуд гарчээ”¹⁵ гэжээ. Иймээс уг хөшөөг эцгийн дурсгалыг хүндэтгэн босгожээ. Энд зохиогчийн өгүүлснээр эрт цагт Лхаст амьдарч байсан хятад хүмүүс нь Хятадад ашиггүй үг үсэг, өгүүлбэрийг арилгасан гэдэг бөгөөд энэ хашааны шороо өвчин анагаахад тустай гэж төвд хүмүүс үздэг байсан ажээ. Бидний бодоход уг хөшөөний үг үсэг, өгүүлбэрийг хятадууд зориуд хусаж арилгасан гэх үндэслэлтэй бөгөөд мөн Төвд эрт дээр үеэс Тан улстай тэмцэлдэн дайтаж байсан нь Хятадын шууд нөлөө, түшмэгийг эсэргүүцэн дагаар ороогүй байсныг гэрчлэх нэгэн баримт болж үлджээ.

Ер нь төвд үндэстэн БНХАУ байгуулагдахаас өмнө эрт дээр цагаас бүрэлдэн тогтсон улс төрийн тогтвортой байгуулалтай, биеэ даасан эзэнт төртэй, түүхэн хөгжлийн урт удаан замыг туулан-өнгөрүүлсэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшингээр ялгаатай төдийгүй, оюуны соёл, шашнаараа Хятадаас эрс ялгаатай угсаа гарал, ахуй амьдрал, зан заншлын хувьд тэс өөр үндэстэн байсан тухай төвд хэлээр бичсэн сурвалж бичигт бүр ч олонтой тусгагдсан байдаг юм. Үүнд: Баруун үзэмчин хошууны Гүн Гомбожав бичихдээ: “Хятад ба Их хятад”, “Төвд ба Их Төвд” гэжээ.¹⁶ Хятад Төвд хоёр эрх тэгш төртэй эзэнд улс байсан бөгөөд уламжлалт шашин, түүх бичлэгийн үүднээс Замбуу (Ази) тивд Энэтхэг, Хятад, Төвд Монгол Улсууд адилхан эн зэрэгцсэн биеэ даасан эзэнт улсууд байсан юм гэдгийг эл сударт бүрэн харуулжээ. Төвд хэлээр бичсэн олон арван судар, түүхэн сурвалж материалыг үзэхэд дээрх асуудал олонтаа хөндөгдсөн нь үзэгддэг. Харин Төвд орон 1951-1980 оны хооронд нийгмийн өөрчлөн байгуулалт хийсэн, хан үндэстэн нэвтрэн орох болсон буюу Төвдийн ард түмний түүхэнд учруулсан хор уршиг, дагавраас болж өнгөрсөн үйл явдлын хэлбэр, агуулга, хувьсал өөрчлөлтийг он цагаан хуваан үзвэл: 1950 оны 10-р сард БНХАУ Төвдийг өөртөө нэгтгэсэн үеэс эхлэн Хятад нь Төвдийг бүх талаар хянах байдал нэмэгджээ.

1955 оноос эхлэн 1959 онд Хятадын нөлөө Төвдийн амьдрал, нийгэм-эдийн засагт ихээхэн нэвтэрч давамгайлах болжээ.

1960 оноос 1966 онд “Соёлын хувьсгалын” босгонд Хятад нь Төвдөд шашин төрийн бүтэц, шашны зохион байгуулалтыг устгах Төвдөд хан үндэстнийг бөөн бөөнөөр суурьшуулах болсон юм.

¹⁵ Source book on Buddiism in mainland (1949-1967) Gong-Kong, 1967, 467 tal

¹⁶ “Хятад оронд бүддийн шашин дэлгэрсэн түүх” (төвд хэлээр) 2 а тал.

1966-1968 онд Төвдөд “соёлын хувьсгалын” үе байсан бөгөөд 2 жилийн дотор “соёлын хувьсгал”-аар “дөрвөн хуучин” (хуучин соёл, хуучин бодлого, хуучин зан заншил, хуучин үзэл санаа)-ыг өөрчлөх нэрийдлээр улаан хамгаалагчид довтолгоон хийж 1966 оны 8-р сарын 25-нд Лхасын Их зуугийн гол дуганыг эвдэн сүйтгэж, шашны ном судар, хөрөг зэргийг галдан шатааснаас гадна бурхны дүр гундааг эвдэлж хэмхлэн голд хаях зэрэг адал балмад хэрэг үйлдсэн билээ.

“Соёлын хувьсгал”-ын дараах 1969-1980 оны хооронд Хятадын удирдлага Төвдөд “эдийн засгийн шинэчлэлт” явуулан, олон хятад хүнийг суурьшуулж цэргийн барилга байгууламж, их барих болсон нь Төвдийн ард түмний эсэргүүцэлтэй тулгарчээ. Мөн Төвдийн боловсролын системд Хятадын соёл өргөн нэвтэрч, түүгээр ч үл барам хятад, төвд хүнийг албан журмаар гэр бүл болгож байгаа нь төвд үндэстэнг уусгах бодлого гэхэд хилсдэхгүй юм. Энд нэгэн мэдээг дурдахад одоогийн Төвд бол БНХАУ-ын үндэстний томоохон мужуудын нэг бөгөөд Төвдийн нутаг дэвсгэр 1.2 сая хавтгай дөрвөлжин км, сүүлийн үеийн албан ёсны бүртгэлээр хүн ам нь 1,892,393. Үүнээс хятад хүн 91,720 байгаа гэх бөгөөд төвд хүн 1,800,673 буюу 95,2 хувь юм.¹⁷

Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төвдийн ламын шашин хүн амын өсөлтийг саатуулж байгаагийн гол үзүүлэлт гэсэн социологийн судалгаа гаргасан боловч харин гадаадад цагаачлан амьдарч буй 85,000 төвдийн талаар огт дурдахгүй байна. Төвдийн хүн амын өсөлт бусад үндэстнийхээс доогуур байгааг харьцуулан бичихдээ, 1953-1978 оны бүх улсын хятад үндэстний өсөлт 63,3%, бусад саяас дээш хүн амтай 13 үндэстний цөөнхийн 5 нь 70%-иас нэлээд дээш, 4 нь 50-70%-иас нэлээд дээш, 2 нь 30-50% харин Төвд 24,5%-ийн өсөлттэй¹⁸ гэжээ. Энэхүү бидний өгүүлэн буй эл шүүмж бол Төвдийн талаар хятад болон бусад сурвалж бичгийн мэдээ, тэдний тухайд Төвдийн түүх, нийгэм, соёлын талаар хүмүүсийн бичсэн том, жижиг ном, өгүүллийг нягтлан Төвдийн нийгэм-эдийн засгийн байгуулал, соёл, угсаа гарлын асуудлыг хамаарахыг хичээсэн билээ. Төвдийн тухайд Хятадын материалаас гадна сурвалж бичгийн мэдээг аль болохоор нягтлан үзэхийг зохиогч эрэлхийлэв. Төвд үндэстэн хятад улстай эрх тэгш харилцаатай төрийн байгуулалтай, өөрийн засаг төртэй, эзэн хаантай улс байсан. Төвд нь 1950 онд Хятадын бүрэлдэхүүнд орж автономит район болсон хүртэлх асуудал болон хожуу үеийн байдлыг гаргахыг хичээв

Хятадын сурвалжийг Хятадын түүхчид гол төлөв зохиосон байдаг тул тэдний нэлээд нь түүхийг үзэх Хятадын уламжлалт үзэл баримтлан хятад сурвалж материалыг их бага аль нэгэн хэмжээгээр засварлан бичиж байна. Энэ байдалд шүүмжлэлтэй хандах явдал зүй ёсны шаардлагатай зүйл билээ.

Д. Цэдэв

¹⁷ “Үндэстний асуудал” сэтгүүл. 1985. № 2, 44-р тал

¹⁸ “Үндэстний асуудал” сэтгүүл. 1985. № 2, 44-р тал

ПОВЕРХНОСТНОЕ ОТНОШЕНИЕ К ИСТОРИИ ТИБЕТА

(Резюме)

В последние годы в КНР уделяется большое внимание изучению социально-политических, экономических положений, вопросов истории, культуры и происхождения, национальных меньшинств, публикуются немало кино, серии статей. Одной из таких публикаций является рецензируемая здесь статья исследователей истории национальностей Китая Лувсана (тибетец) и Жин Юна (ханьской национальности) под названием “Тибет: История и анекдоты”, опубликованная в № 24, 26 журнала “Пекин ревью” за 1983 г.

Первая часть статьи посвящена вопросам истории их социально-политического строя Тибета с конца VI до начала XVIII века.

В подзаголовке “Соронзонгомбо и принцесса Вэнчин авторы иншут о содании в конце VII века Соронзонгомом, сыном Нанрилоизана, вождя Ярлунгских племен, Тибетского самостоятельного королевства. При этом авторы, придерживаясь традиционных китайских воззрений на историю, искажает действительное историческое событие-Женитьбу тибетского императора Соронзонгомбо (605-649) на принцессу Вэнчин, дочь Тайцзуна, императора Танского государства. Сперва когда тибетский император Соронзонгомбо получил отказ на свою просьбу жениться на принцессу Вэнчин, его войска были вынуждены совершить нападения на пограничные районы Танского государства, чтобы получить согласие на свое предложение и наконец, танский император согласился отдать свою дочь на свадьбу с Соронзонгомбом и тем самым были установлены дружеские отношения между Тибетским королевством и Танским государством. С другой стороны, авторы данной статьи, умаляя вклад тибетского народа в создание своей истории и культуры, преувеличивают в своих выводах роль женитьбы Соронзонгомбо на принцессу Вэнчин, будто она значительно способствовала развитию общества и культуры Тибета. Подобные выводы этих авторов явно противоречат материалистическому пониманию истории.

В статье авторы пишут, что надписи “На памятнике танско-тибетского союза”, находящемся на дверях монастыря в Их зуу в Лхасе, полностью сохранились. Однако, интерпретация надписей на памятнике сделанная в “Краткой национальной истории Тибета” Ван Фурэна и Сувэнди (Сычуань, 1980), на самом деле не соответствует оригиналу. По этому поводу рецензент отмечает, что своевольное искажение памятников и письменных источников некоторыми китайскими историками причиняет ущерб изучению оригиналов редких исторических культурных памятников национальных меньшинств, вводит в заблуждение ученых, изучающих культурное наследие прошлого. Насильственное исправление китайскими историками оригиналов редких памятников под видом “их реставрации”, можно квалифицировать как уничтожение самих памятников-отмечает рецензент.

В тибетских и других источниках существуют множество свидетельств того, что тибетцы с древнейших времен до создания Тибетского автономного района КНР имели свои самостоятельные государства в разные исторические периоды с оригинальной культурой, специфическими национальными обычаями, правами и религией, совершенно отличными от аналогичных Китая. По социально-экономическому развитию тибетский народ также прошёл длительный исторический путь, имевший свои специфические черты.